

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
218 дугаар тогтоолын 38 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
Боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2025.05.21

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн яам

Нэгжийн нэр:

Санхүү, эдийн засгийн бодлогын газар,
Санхүү даатгалын хэлтэс

Албан тушаалын нэр:

Эрүүл мэндийн сайдын багцын нэгдсэн
төсвийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан
ахлах мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн сайдын багцын нэгдсэн төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийг, зохицуулах, хяналт, тайлагналыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулах, үр дүнг тайлагнах, мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн сайдын багцын нэгдсэн төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалт хийж, хяналт тавьж, тайлагнах;
2. Эрүүл мэндийн сайдын багцын эдийн засаг, санхүү, төсвийн нэгдсэн тооцоолол, судалгаа, дүгнэлт, үр дүнгийн тайлагналт хийх;
3. Гүйцэтгэлээр санхүүжих эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн зарцуулалтын эрх олголт, зохицуулалт, хяналт тавьж аргазүйгээр хангах;
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, төсвийн төслийн санал боловсруулах, Сангийн яаманд хянуулах, батлуулах;	Хууль, журмын дагуу төсвийн төсөл боловсруулан батлуулсан байна.	Г, Х
	2.Сайдын багцын эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалтыг хийх,	Батлагдсан төсвийн хүрээнд өглөг, авлагагүй ажилласан байна.	Г, Х
	3.Улсын төсвөөс санхүүждэг Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн төлөвлөлтийн аргачлалыг боловсронгуй болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Нэгдсэн аргачлалтай болсон байна.	Г, Х
	4.Салбарын хуулинд заасан төлбөрийн жишиг хэмжээ тогтоох эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах	Батлагдсан журам	Г, Х
	5.Эрүүл мэндийн сайдын багцын байгууллагуудын төсвийн зохицуулалтын нэгтгэл хийж, төсөвтэй холбоотой нэгдсэн тоо мэдээллийг боловсруулах;	Төсөвт зохицуулалт хийж, Удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангасан байна.	Г, Х
	1.Сайдын багцын эрүүл мэндийн байгууллагуудын	Судалгаа, шинжилгээ дүн хийсэн байна.	Г, Х

2 дугаар зорилтын хүрээнд	төсөв, санхүүгийн нэгдсэн тооцоолол судалгаа, дүн шинжилгээ хийх;		
	2. Сайдын багцны эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн нэгдсэн тооцоо, судалгаа, дүн шинжилгээг хийж зөвлөмж боловсруулах	Судалгаа, дүн шинжилгээ хийсэн байна.	Г, Х
	3. Сайдын багцын эрүүл мэндийн байгууллагуудын цалин хөлс, тэтгэмжийн нэгдсэн судалгаа, дүн шинжилгээ	Судалгаа, дүн шинжилгээ хийсэн байна.	Г, Х
	4. Сайдын багцын эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын судалгааны нэгтгэл, дүн шинжилгээ, өр авлага бууруулах ажлыг зохион байгуулах	Судалгаа, дүн шинжилгээ хийсэн байна. Өр авлагагүй ажилласан байгууллагын тоо	Г, Х
	5. Сайдын багцын эрүүл мэндийн байгууллагуудын төсөв, санхүүгийн талаар арга зүйн зөвлөмж боловсруулж нэгдсэн удирдлагаар хангах;	Харьяа байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1. Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн сар, улирлын хуваарийн өөрчлөлт, зохицуулалт, эрүүл мэндийн сайдын багцын төсвийн нэгтгэлийн программыг хариуцан ажиллуулж, мэдээллийн баазыг тухай бүр нь шинэчлэх;	Санхүүжилтийн сарын хуваарьт өөрчлөлт орсон байна.	Г, Х
	2. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын урсгал төсвийн нэгтгэл зохицуулалтыг хийх, хяналт тавих;	Урсгал төсөвт зохицуулалт хийгдсэн байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;	Төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай үзүүлсэн байна.	Г, Х
	2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нэгдсэн зохицуулалт, хяналт, арга зүйн зөвлөгөө	Шилэн дансны тухай хууль хэрэгжсэн байна.	Г, Х

3.Байгууллагын болон нэгжийн албан тушаалын чиг үүрэг, үйл ажиллагааны холбогдох асуудлаар жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, сар, улирлын тайланг боловсруулах, төлөвлөх, тайлагнах;	Гүйцэтгэлийн үр дүн зохих журмын дагуу үнэлж, дүгнэгдсэн байна	Г
4.Байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх;	Төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай үзүүлсэн байна.	Г
5.Албан хэрэг хөтлөлт, тайлан мэдээг цаг тухайд нь тайлагнах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Албан хэргийн стандартын дагуу хөтөлсөн байна.	Г
6.Байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах болон мэргэшүүлэх сургалт, арга хэмжээнд хамрагдах.	Сургалтад хамрагдсан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	- эдийн засаг /0311/; - нягтлан бодох бүртгэл /0411/; - санхүү /0412/.	
Мэргэшил		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, үр дагаврыг хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, хариуцах;

		- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад.
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - хүний эрхийн мэдрэмжтэй байх; - жендерийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах; - бусад

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Санхүү, эдийн засгийн бодлогын газрын Санхүү, даатгалын хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-

Бусад харилцах субъект

1. Яамны газар, хэлтсийн холбогдох албан тушаалтан, эрүүл мэндийн байгууллагуудын дарга, холбогдох албан хаагч;
2. Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын холбогдох албан хаагч;

		3.Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан хаагч, иргэн.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ		
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>		<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА.....  /Б.БАТБАЯР/ 2025 оны ... сарын ... -ны өдөр		<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 25.05.21 <u>Дугаар:</u> 2.18
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:		
<u>Байгууллагын нэр:</u> ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ Шийдвэрийн огноо: Дугаар: (тамга/тэмдэг) ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА.....  /Д.ОЧИРБАТ/ 2025 оны дугаар сарын -ны өдөр		

